Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

Боловсрол шинжлэх ухааны яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас Соёл, урлагийн их сургуулийн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж ажиллаж байгаа эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёл, урлагийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 8,825.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 88.3 сая төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Соёл, урлагийн их сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 585.4 сая төгрөгөөр буюу 3 хувиар буурч, материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өглөгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн тайлангийн тодруулга

мянган төгрөг			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,851,317.1	3,438,319.9	587,002.8
Авлага	1,188,217.7	793,910.7	(394,307.0)
Урьдчилгаа	3,532.4	6,675.0	3,142.6
Бараа материал	1,224,208.6	1,095,248.5	(128,960.1)
Үндсэн хөрөнгө	11,951,871.1	11,299,577.4	(652,293.8)
Нийт хөрөнгийн дүн	17,219,146.9	16,633,731.4	(585,415.5)

Өр төлбөрийн дүн	1,241,709.9	1,375,334.0	133,624.2
Богино хугацаат өглөг	1,241,709.9	1,375,334.0	133,624.2
Цэвэр хөрөнгө/эзний өмч	15,977,437.1	15,258,397.4	(719,039.7)
Өмч-төрийн	4,684,013.9	4,684,013.9	-
Хуримтлагдсан үр дүн	5,848,886.6	5,129,846.9	(719,039.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,444,536.6	5,444,536.6	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	17,219,146.9	16,633,731.4	(585,415.5)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,438.3 сая төгрөг болж 587.0 сая төгрөгөөр өссөн нь 211.5 сая төгрөг төлөгдөж, боловсролын зээлийн сангаас суралцагчдын санхүүжилтийн 689.5 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Авлага дансны үлдэгдэл 793.9 сая төгрөг болж 394.3 сая төгрөгөөр буурсан нь төлбөртэй үйлчилгээний авлага 313.4 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага 80.9 сая төгрөгөөр буурсан;
- Бараа материал дансны үлдэгдэл 1,095.2 сая төгрөг болж 129.0 сая төгрөгөөр буурсан нь худалдан авалт 475.9 сая төгрөг, хандивын орлогоор 9.7 сая төгрөг, нийт 485.6 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 478.9 сая төгрөг, захирлын 2021 оны А/140 тоот тушаалаар 130.2 сая төгрөгийн бараа материал акталж данснаас хассан, 5.5 сая төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгө дансанд шилжүүлж нийт 614.6 сая төгрөгөөр хасагдсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11,199.6 сая төгрөг болж, 652.3 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2020 оны 727 тоот тогтоолын дагуу өөрийн хөрөнгөөр худалдан авсан 310.9 сая, хандивын орлогоор 116.6 сая, бараа материалын дансанд шилжүүлсэн 5.5 сая төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 363 тоот тогтоолын дагуу акталж данснаас хассан 295.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж 127.7 сая төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосон, А-1/1147 тоот албан бичгийн зөвшөөрлийн дагуу 223.7 сая төгрөгийн хөрөнгийн акталж, 1,180.7 сая төгрөгийн элэгдлийн зардал бүртгэсэн;
- Богино хугацаат өглөг дансны үлдэгдэл 1,375.3 сая төгрөг болж 133.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь урьдчилж орсон орлого 209.7 сая төгрөгөөр нэмэгдэж, бусад өглөг 76.1 сая төгрөгөөр буурсан.

3.6 Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3, Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйл, Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу Соёл урлагийн их сургуулийн захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

3.6.1 Зорилтот түвшний төлөвлөлт

Соёл, урлагийн их сургуулийн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 12 дугаар тоот тогтоолоор Соёл, урлагийн их сургуулийн 2021 оны төсөв, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 11,228.7 сая төгрөгөөр, үүнээс үйл ажиллагааны орлого 8,310.5 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 2,642.2 сая, нийт зардлыг 11,228.7 сая төгрөгөөр үүнээс урсгал зардалд 11,153.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Удирдах зөвлөлийн 2021 "Төсвийн тодотгол хийх тухай" оны 04 дугаар тоот тогтоолоор орлого, зардлыг 1,136.7 сая төгрөгөөр бууруулж нийт орлого, зардлыг 10,092.0 сая төгрөгөөр баталсан.

3.6.2 Зорилтот түвшний төлөвлөгөөний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 97.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 128.2 сая төгрөг, БЗС-аас 689.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 6,716.1 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 439.8 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн орлогоос 293.0 сая төгрөг нийт 8,363,8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд 7,751.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 23.6 сая төгрөг, нийт 7,775.3 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Сургалтын төлбөрийн орлого нь 491.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь БЗС-аас 673.0 сая төгрөгийн санхүүжүүлт хийгдсэнээс шалтгаалсан байна.

Туслах үйл ажиллагааны орлого 41.0 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн орлого 155.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн ШУТ Сангийн 4.4 сая төгрөг, оюутны замын зардлын хөнгөлөлтийн санхүүжилт 12.3 сая төгрөгөөр буурсан байна.

Орон нутгийн төсвийн санхүүжилт нь суралцаж буй оюутны тооны гүйцэтгэлээс шалтгаалан 11.2 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Гүйцэтгэлийн нийт зардал 7,775.2 сая төгрөг буюу 77.0 хувийн биелэлттэй байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,280.5 сая төгрөг, байр ашиглалт 64.4 сая, хангамжийн материал 139.4 сая, бусад урсгал шилжүүлгийн зардал 107.2 сая төгрөгөөр буюу нийт урсгал зардлыг 2,316.4 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 0.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2020 оны 224 тоот тогтоолоор Соёл, урлагийн их сургуулиас “Дүрслэх, дизайн урлагийн дээд сургууль”-ийг тусгаарлан “Дүрслэх урлагийн академи, дээд сургууль” болгон өөрчилж, сургуулийн байр, бусад эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх шийдвэр гарч санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл 627.5 сая төгрөгөөр буруулсан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд нийт зардлыг 23 хувь буюу 2,316.7 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Соёл, урлагийн их сургуулийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Соёл, урлагийн их сургууль нь 2021 онд нийт 25,762.4 сая төгрөгийн 157 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 25,762.4 сая төгрөгийн мэдээллийг хугацаанд нь байршуулж зөрчил гаргаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Удирдах зөвлөлийн "Төсвийн тодотгол хийх тухай" 04 дүгээр тогтоолоор сургалт судалгаа, уран бүтээлийн төсвийг 20.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан.

Энэ нь Монгол улсын засгийн газрын 2021.02.17- ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д "...Зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл,...батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллах, Албан шаардлага өгөх .

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, төсвийн тодотголоор сургалт судалгаа, уран бүтээлийн төслийг нэмэгдүүлж баталсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 61.3 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илрүүлж, жилийн эцсийн тайлангаар 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэв.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 3.0 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж, 3 албан шаардлагаас 16.7 сая төгрөгийн 2 албан шаардлагыг хэрэгжүүлж, 28.0 сая төгрөгийн 1 албан шаардлага бүрэн хэрэгжээгүй, зөвлөмжийн биелэлт 83.3 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	44155.7	2	16,196.70	1	27,959.0	66.7
Зөвлөмж	1	3,000.00	1	3,000.00	1	-	100.0
Нийт дүн	4	47,155.70	2	19,196.70	1	27,959.00	83.3

мянган төгрөг

Хэрэгжүүлээгүй албан шаардлага нь 2010-2015 оны хооронд үүссэн 28.0 сая төгрөгийн найдваргүй авлагатай холбоотой асуудал байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Соёл, урлагийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараагийн аудитаар анхаарах асуудал үүсээгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 62.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 57.3 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 5.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн. Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 62.3 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 88.3 сая төгрөгөөс 26.0 сая төгрөгөөр бага тул зөрчилгүй дүгнэлт өгсөн.

4.1 Албан шаардлага

1. Өмнөх оны аудитаар 44.2 сая төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 2015-2016 онд үүссэн 24 оюутны сургалтын төлбөрийн авлагын үлдэгдэл 28.0 сая төгрөг байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.", Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр болсон албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй. Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх.

2. Сургуулийн танилцуулга сурталчилгаа, санхүүчдын тэмцээн, шилдэг багш шалгаруулалт, бэлэг дурсгалд 29.4 сая төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Монгол улсын засгийн газрын 2021.02.17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүр төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж зардлыг гаргахгүй байх...", 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх." 1.7 "...байгууллага, хамт олныг суртацилах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажилладаг байх. Албан шаардлага өгөх.

4.2 Зөвлөмж

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нэр бүхий захиргааны 6 ажилтанд илүү цагаар ажиллах шийдвэргүй, ажлын цагийн тооцоог үндэслэн 1.1 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 74.2 заалт "Хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тохиролцоогүй бол дор дурдсанаас бусад тохиолдолд ажилтныг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно...", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 заалт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх,

санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн ба зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ажилчидад илүү цаг олгохдоо анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, хуульд зааснаас бусад тохиолдолд илүү цагийн хөлс олгохгүй байх

2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төв сургууль нь 3.9 сая төгрөгийн номыг худалдан авч нэгжийн хүсэлт, захиалга, шаардах хуудас, баримтгүйгээр бусад салбар сургуулиудад хуваарилсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.3 заалт "Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 14.2-т зааснаас бусад өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг дүрэмдээ заасан эрх бүхий удирдах байгууллагаар батлуулан мөрдөж болно." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сургууль, нэгжээс гаргасан номны хэрэгцээ, захиалгыг үндэслэн худалдан авалт хийж, анхан шатны баримтын дагуу олгодог байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	Соёл, урлагийн их сургууль	АХГ-2022/12 /НА-СТА-ТӨА	Өмнөх оны аудитаар 44.2 сая төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, авлагын үлдэгдэл 28.0 сая төгрөг байна.	Хүчин төгөлдөр болсон албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй	1	27,959.0					1	27,959.0	1			
2	Соёл, урлагийн их сургууль	АХГ-2022/12 /НА-СТА-ТӨА	Сургуулийн танилцуулга сурталчилгаа, санхүүчдын тэмцээн, шилдэг багш шалгаруулалт, бэлэг дурсгалд 29.4 сая төгрөгийг зарцуулсан байна.	Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажилладаг байх.	1	29,406.0					1	29,406.0				
3	Соёл, урлагийн их сургууль	АХГ-2022/12 /НА-СТА-	Нэр бүхий захиргааны 6 ажилтанд илүү цагаар	Ажилчидад илүү цаг олгоходоо анхан	1	1,083.5									1	1,083.5

		ТӨА	ажиллах шийдвэргүй, ажлын цагийн тооцоог үндэслэн 1.1 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгосон.	шатны баримтыг бүрэн бүрдүүлж, хуульд зааснаас бусад тохиолдолд илүү цагийн хөлс олгохгүй байх												
4	Соёл, урлагийн их сургууль	АХГ-2022/12/НА-СТА-ТӨА	Төв сургууль нь 3.9 сая төгрөгийн номыг худалдан авч нэгжийн хүсэлт, захиалга, шаардах хуудас, баримтгүйгээр бусад салбар сургуулиудад хуваарилсан	Сургууль, нэгжээс гаргасан захиалгыг үндэслэн худалдан авалт хийж, анхан шатны баримтын дагуу олгодог байх	1	3,885.0									1	3,885.0
Дүн					4	62,333.5					2	57,365.0	1		2	4,968.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	Соёл, урлагийн их сургууль	АХ Г-2022/12/НА-СТА-ТӨА	СУИС-ийн удирдах зөвлөлийн 04 дугаар "Төсвийн тодотгол хийх тухай" тогтоолоор сургалт судалгаа, уран бүтээлийн төслийг 20.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж	Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажилладаг байх.	1						1					

			баталсан.													
			Дүн		1					1						
			Нийт дүн		5	62,333.5				3	57,365.0	1		2	4,968.5	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 560/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/12/НА-СТА-ТДА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Соёл, урлагийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сургуулийн танилцуулга сурталчилгаа, санхүүчдийн тэмцээн, шилдэг багш шалгаруулалт, бэлэг дурсгалд 29,405,988.00 төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүр төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж зардлыг гаргахгүй байх...", 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх", 1.7 "...байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх Засгийн газрын тогтоолыг мөрдөж, төсөвт зардлыг хэмнэж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг захирал Э. Сонинтогос, нягтлан бодогч Ж.Жагармаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ЭНИЧ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Т.ЧИНТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй бүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-231.Docx

0001081440



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 562/А0150058

Улаанбаатар хот

АХТ-2022/КЛНА-СТА-ТДА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Соёл, урлагийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Удирдах зөвлөлийн "Төсвийн тодотгол хийх тухай" 04 дүгээр тогтоолоор сургалт, судалгаа, уран бүтээлийн төсвийг 20,000,000.00 төгрөгөөр нэмэгдүүлж баталсан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын 1.1 "...Зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, ... батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх Засгийн газрын тогтоолыг мөрдөж, төсөвт зардлыг хэмнэж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг захирал Э.Сонинтогос, ерөнхий нягтлан бодогч Ж.Жагармаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б. СЭРЖМЯДАГ

ЭНИЧ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г. ЧИНТУЯА



0001081442



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 561/20150058

Улаанбаатар хот

АНГ - 2022/12/11А - СТА - ТДА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Соёл, урлагийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн 44,283,427.05 төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 2015-2016 онд үүссэн 24 оюутны сургалтын төлбөрийн авлагын үлдэгдэл 27,959,036.15 төгрөг байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Зөрчил гаргасан сургалт эрхэлсэн дэд захирал Д.Одсүрэнд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг захирал Э.Сонинтогост даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ЭНИЧ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Г. ЧИНТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-230.Docx

0001081438

[illegible]